

- 22
- 8.10. Компани энгийн хувьцаа гаргахаас гадна давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг, хувьцаанд хамаарах үнэт цаас гаргаж болно.
- 8.11. Компанийн зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, бусад үнэт цаас гаргах шийдвэрийг ТУЗ гаргана. Үнэт цаас гаргах тухай шийдвэрт гаргах үнэт цаасны төрөл, тоо ширхэг, нэрлэсэн үнэ, үнийн дүн, үнэт цаас гаргагч төвлөрүүлсэн хөрөнгийн зориулалт, үнэт цаасыг нийтэд эсхүл хаалттай захиалгаар худалдах, энгийн хувьцаанаас бусад үнэт цаас нь энгийн хувьцаанд хөрвөх бол хөрвөх нөхцөл зэргийг заасан байна.
- 8.12. Үнэт цаасын нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн бол Үнэт цаасны хорооноос баталсан журмын дагуу бүртгүүлэх, хөрөнгийн биржид бүртгүүлэх, нийтэд сурталчлах, андерайтор бол зуучлах үнэт цаасны компанитай гэрээ байгуулан ажиллах асуудлыг гүйцэтгэх захирал хариуцан зохион байгуулна.
- 8.13. Компанийн зарласан хувьцаанаас ТУЗ-ийн шийдвэрээр гүйлгээнд нэмж гаргасан үед хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх олгохын тулд хувьцаа худалдаж авах эрхийн бичиг гаргана. Хувьцаа эзэмшигчид хувьцаа худалдан авах давуу эрхийг гэрчлэх эрхийн бичгээ бүрэн болон хэсэгчлэн худалдаж болно. Хувьцаа худалдаж авах эрхийн бичгийг биет бус үнэт цаасны хэлбэрээр гаргаж Үнэт цаасны хороо, Хөрөнгийн биржид бүртгүүлнэ.
- 8.14. Хувьцаа худалдаж авах эрхийн бичгээ ашиглан хувьцаа худалдаж авах захиалга, хөрөнгийн биржийн төвлөрсөн хадгаламж дах компанийн дансад захиалсан хувьцааны үнийг төлсөн баримт зэргийг зар хүрснээс хойш 15 хоногийн дотор компанид ирүүлээгүй хувьцаа эзэмшигчдийн хувьцаа худалдаж авах эрхийн бичгийг ТУЗ-ийн шийдвэрээр нийтэд арилжаалж болно. Хувьцаа эзэмшигч нь өөрт ногдох хувьцаа худалдаж авах эрхийн бичгээ бүрэн болон хэсэгчлэн бусдад худалдсан бол энэ тухай бичгээр худалдаж авах хувьцааны үнийг төвлөрсөн хадгаламж дах компанийн дансанд төлсөн байна. Хувьцаа худалдаж авах эрхийн бичгийн хугацаа дуусмагц компанийн ТУЗ түүнийг хүчингүй болгох шийдвэр гаргаж Үнэт цаасны хороо, Хөрөнгийн биржид мэдэгдэж бүртгэлээс хасуулна.
- 8.15. Компанийн хувь нийлүүлсэн дүнгээс илүүгүй хэмжээгээр 3 жил хүртэл хугацаатай өрийн бичиг гаргах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. Шийдвэрт гаргах өрийн бичгийн тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, нөхцөл эргэж төлөгдөх хугацаа, эргүүлэн авах үнэ, энгийн хувьцаанд хөрвөх эсэхийг заасан байна.
- 8.16. Компанийн өөрийн хөрөнгийн дүнгээс илүүгүй хэмжээгээр 3-аас дээш жилийн хугацаатай өрийн бичиг гаргах асуудлыг компанийн хувьцаа эзэмшигчдийн



хурлаар хуралд оролцож буй саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Шийдвэрт энэ дүрмийн 5-ын 5.5.1-д заасан зүйлсийн мөн адил тусгана.

- 8.17. Компанийн тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцаа тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдан авах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно. Опционоор худалдаж авч болох энгийн хувьцаа нь гүйлгээнд байгаа нийт хувьцааны 25 хувиас бага бол опцион гаргах шийдвэрийг ТУЗ, түүнээс бусад хувьцаа эзэмшигчдийн хурал гаргана. Шийдвэрт гаргах опционы тоо нэгж опцион эзэмшигчдийн худалдан авч болох хувьцааны тоо, хувьцаа худалдаж авах үнэ, опционы хүчинтэй байх хугацаа, опционы үнэ зэргийг заасан байна.
- 8.18. Компаниас гаргасан хувьцааны хөрвөх үнэт цаасаар хөрвөх хувьцааны тоо, нийт гаргасан опционоор худалдах хувьцааны тоо, гүйлгээнд гаргасан хувьцааны тоо зэргийн нийлбэр нь нийт зарагдсан хувьцааны тооноос илүү байж болохгүй.
- 8.19. Хувьцаа бусад үнэт цаасыг "Компанийн тухай" хуулийн 56-р зүйлд заасны дагуу ТУЗ тогтооно.
- 8.20. Компаниас нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг мөнгө, үнэт цаас, эд хөрөнгийн хэлбэрээр хийж болно. Үнэт цаасны төлбөрт тооцох мөнгөн бус хөрөнгийн үнэлгээг уг хэлцэл хийхийг сонирхогч бус ТУЗ-ийн гишүүд санал нэгтэй тогтооно. Үнэлгээг тогтоохдоо мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэс болгоно.
- 8.21. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчтэй нь тохиролцсоны үндсэн дээр худалдан авч болно. Компани энгийн хувьцаанаас бусад цаасыг бүхэлд нь буюу эсвэл зарим хэсгийг худалдан авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджаас 25 хувиас илүүгүй байна.
- 8.22. Хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн худалдах эрхийг хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд энгийн хувьцаанаас 5-аас дээш хувийг эргүүлэн авах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хуралд оролцогчдын дийлэнхи олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 8.23. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг худалдаж авах шийдвэрийг энэ дүрмийн 8-ын 13-д зааснаас бусад тохиолдолд ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэртээ худалдаж авах үнэт цаасны төрөл, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заана.
- 8.24. Компани дараах нөхцөлд өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн авах шийдвэр гаргаж болно.

А. Эргүүлэн авах үүрэг бүхий энгийн хувьцааг эргүүлэн авсан.

Б. Үнэт цаасаа эргүүлэн авсны дараа төлбөрийн чадвартай байх.




В. Компанийн өөрийн хөрөнгө нь гаргасан давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээ зэргийн нийлбэрээс илүү байх.

**Ес. Компанийн удирдлага, түүний эрх хэмжээ**

**А. Хувьцаа эзэмшигчдийн хурал**

- 9.1.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
- 9.1.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.
- 9.1.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулах ба хурлыг зарлаагүй бол ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болж, хурал зарлах эрх нь ТУЗ-ийн 2 буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн ба саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигчидэд шилжинэ. Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, хуралдуулах зардалыг компани гаргана.
- 9.1.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ын дарга удирдан явуулна. Компанийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчийн саналаар хурлын аргыг сонгох асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй гишүүдийн олонхийн саналаар сонгож шаардлагатай тохиолдолд ТУЗ, эсхүл саналын эрхийн 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн санаачлагаар ээлжит бус хурлыг “Компанийн тухай” хуульд заасан журмын дагуу зарлан хуралдуулж болно.
- 9.1.5. Шаардлагатай тохиолдолд ТУЗ, эсхүл саналын эрхийн 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн санаачлагаар ээлжит бус хурлыг “Компанийн тухай” хуульд заасан журмын дагуу зарлан хуралдуулж болно.
- 9.1.6. Дор дурьдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:
  - а. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулгыг батлах;
  - б. Нийлэх, нэгдэх, хуваах, өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөх байгуулах;
  - в. Компанийн өрийг хувьцаагаар солих;
  - г. Компанийг татан буулгах, татан буулгах комиссыг томилох;
  - д. Хувьцааг хуваах, нэгтгэх;
  - е. ТУЗ-ийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;





- ё. Хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах, давуу эрхийг хувь нийлүүлэгчдэд эдлүүлэх эсэх;
  - ж. Компанийн жилийн үйл ажиллагааны талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
  - з. ТУЗ-аас хэлэлцүүлэхээр оруулсан их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэлийг батлах;
  - к. Компанийн өөрийн гаргасан нийт хувьцааны 5-аас илүү хувийг буцааж худалдаж авахыг зөвшөөрөх;
  - л. ТУЗ -ийн цалин урамшууллын хэмжээг батлах
  - м. ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд;
- 9.1.7. Нэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход саналын эрхийн тоог тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох гишүүний тоогоор үржүүлж тодорхойлно.
- 9.1.8. Компанийн хурлын бүрэн эрхэд хамаарах бүх асуудлыг хуралд оролцогчдын саналын эрхийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 9.1.9. Хурлын тухай мэдээллийг нийтэд хүргэх, хуралд оролцох эрхтэй гишүүдийг тодруулах санал авах ажиллагааг “Компанийн тухай” хууль, Үнэт цаасны хорооноос баталсан журмын дагуу явуулна.
- 9.1.10. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргаж, хурлаар хэлэлцэх асуудлын товьг тогтоосноос хойш хувьцаа эзэмшигчдийн хурлаар яаралтай хэлэлцэж шийдвэрлэх асуудал гарсан тохиолдолд хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор уг асуудлыг хэлэлцэхээр шийдвэр гаргаж болно.
- 9.1.11. Компанийн саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. Энд заасан хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж дахин хуралдах өдрийг товлон энэ тухай протокол үйлдэн ТУЗ-ийн дарга гарын үсэг зурна. Хойшлогдсон хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчилж болохгүй.
- 9.1.12. Саналын эрхийн 20-иос дээш хувийг эзэмшигчид оролцсоноор хойшлогдсон хурал хүчин төгөлдөр болно.
- 9.1.13. Хойшлогдсон хурлыг ажлын 20 хоногийн дотор хуралдуулна. Хойшлогдсон хурал хуралдахаас ажлын 7 ба түүнээс дээш хоногийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.
- 9.1.14. Хойшлогдсон хуралд бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй.





9.1.15. Хойшлогдсон хурал ажлын 20 хоногийн дотор хуралдаж чадахгүй бол шинээр хурал зарлаж хүчин төгөлдөр болох ирцийг энэхүү дүрмийн 9.1.11-д зааснаар тогтооно.

9.1.16. Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдуулахгүйгээр хувь цаа эзэмшигчдээс эчнээ санал хураах замаар шийдвэрлэж болно. Эчнээ санал хураалтыг “Компанийн тухай” хуульд заасан журмын дагуу явуулна. Ээлжит хурлыг болон доорхи асуудлыг шийдвэрлэх хурлыг эчнээ санал хураалтаар оруулахыг хориглоно.



- А. Компанийн дүрмийг өөрчлөх, шинэчилсэн найруулгыг батлах;
- Б. Компани нэгдэх, нийлэх, хуваах, татан буулгах, зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх;

9.1.17. Компанийн нийт гаргасан хувьцаанаас 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувь цаа эзэмшигч нь өөрөө эчнээ санал хураалтын дүнг нэгтгэн гаргах тооллогын комисст үйл ажиллагааг ажиглагчаар оролцох эрхтэй.

9.1.18. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг “Компанийн тухай” хуульд заасан журмын дагуу хөтөлж, баталгаажуулан хадгална.

Б. Толоолон удирдах зөвлөл

9.2.1. ТУЗ нь дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- А. Энэ дүрэмд заагаагүй үйл ажиллагааны чиглэлийг тогтоох;
- Б. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын бүртгэлийн өдөр, хурлын товыг тогтоох;
- В. Компанийн зарласан хувьцааны төрөл болон хэмжээнд багтаан хувьцаа нэмж гаргах. Нэмж гаргах хувьцаа нь энэ дүрэмд заасан их хэмжээний хэлцэлд хамаарах боло хувьцаа нэмж гаргах асуудлыг ТУЗ-ийн гишүүд санал нэгтэй шийдвэрлэнэ. Санал нэгтэй шийдвэрлэж чадаагүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэнэ.
- Г. Хувьцаанд хамаарах бусад үнэт цаас гаргах;
- Д. Компанийн тухай хуулийн 56-р зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
- Е. Өөрийн гаргасан нийт энгийн хувьцааны 5 хүртэл хувийг болон бусад үнэт цаасыг эргүүлэн авах, худалдан авах;


- Ж. Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;
- З. Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох шагнал урамшууллын хэмжээг тогтоох;
- И. Компанийн аудиторыг сонгох, түүнтэй хийх гэрээний нөхцлийг тогтоох;
- К. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;
- Л. Ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тогтоох;
- М. ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмыг батлах;
- Н. Компанийн салбар төлөөлөгчийн газрыг байгуулах;
- О. Компанийг өөрчлөн байгуулах, төсөл боловсруулж хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Ө. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотойгоос бусад их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- П. Сонирхолын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- Р. Компаниас тусгаарлах тухай шийдвэр гаргах;
- С. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал;
- 9.2.2. Уг дүрмийн Б хэсгийн д,и,ө,п-д заасан асуудлыг шийдвэрлэхэд ТУЗ-ийн хараат бус гишүүд оролцож саналаа өгнө. ТУЗ-ийн хараат бус гишүүн гэж өөрөө эрхүй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компаний энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй, компанид албан тушаал эрхэлдэггүй, төрийн албан хаагч бус, компаниаар ямар нэгэн бизнесийн холбоогүй хүнийг хэлнэ
- 9.2.3. Компаний төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байна. Үүний гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 1 жилийн хугацаатай сонгох бөгөөд улируулан сонгож болно. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумлятив аргыг хэрэглэнэ
- 9.2.4. Удаан хугацаагаар үүргээ биелүүлж чадахгүй болсон эсвэл нас барсан тохиолдолд ТУЗ-өөс түр томилно.
- 9.2.5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хууль журамд заасан хугацаанд зарлаагүй бол Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болно.
- 9.2.6. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос сонгоно.
- 9.2.7. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүрэг хүлээнэ.





9.2.8. ТУЗ-ийн хурлыг улиралд 1 удаа хуралдуулна. Ингэхдээ онлайн болон урьдчилан санал өгөх хэлбэрээр хуралдуулж болох ба үүнийг ТУЗ-ийн дотоод вйл ажиллагааны журмаар батална. Шаардлагатай тохиолдолд нэмэлт хуралдаан хийж болно. ТУЗ-ийн шийдвэр нь тогтоол байх бөгөөд тогтоолд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

9.2.9. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхи нь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болж бөгөөд хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. "Компанийн тухай" хууль болон энэ дүрмээр тухайн шийдвэрлэж байгаа асуудлаар ТУЗ-ийн зарим гишүүд санал өгөх эрхтэй байвал шийдвэрийг саналын эрхтэй ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. ТУЗ-ийн хуралд гишүүн бүр 1 саналын эрхтэй байна. ТУЗ-ийн дарга саналын давуу эрх эдлэхгүй.



9.2.10. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитийн, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх ба эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувь нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна. Эдгээр хороод нь тодорхой чиг үүрэгтэй бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах, шийдвэр гаргах эрхтэй

А. Аудитийн хорооны дарга нь хараат бус гишүүн байх ба энэ хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна

- Компаний нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх
- Санхүүгийн тайлангийн бодит байдалд хяналт тавих
- Аудитийн байгууллагыг сонгох
- Их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих

Б. Нэр дэвшүүлэх хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

- Компаний төлөөлөн удирдах зөвлөл ба Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчидэд тавих шаардлагыг тодорхойлох, тэдгээрийг үнэлэн сонгон шалгаруулах
- Хувьцаа эзэмшигчидийн хуралд танилцуулах
- Хөдөлмөрийн гэрээ боловсруулах
- Төлөөлөн удирдах зөвлөл ба Гүйцэтгэх удирдлагын ажилд дүгнэлт өгөх

В. Цалин урамшууллын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна

- Төлөөлөн удирдах зөвлөл ба Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын бодлого батлах
- Цалин урамшууллын дээд хязгаар тогтоох
- Ажлын үр дүнтэй холбогдсон урамшууллын систем боловсруулах



### В. Гүйцэтгэх захирал

- 9.3.1. Гүйцэтгэх захирал нь энэ дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 9.3.2. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно.
- 9.3.3. Гүйцэтгэх захирал нь өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад сонгогдон ажиллаж болно. Харин өөр компани, аж ахуйн нэгжийн гүйцэтгэх удирдлагаар ажиллахыг хориглоно.
- 9.3.4. Гүйцэтгэх захирлын эрх үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс урамшуулал зэргийг ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заана.
- 9.3.5. Энэ дүрэмд ТУЗ-өөр байгуулах шаардлагатай их хэмжээний хэлцлээс бусад хэлцэл хийх, компанийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах, эрх бүхий албан тушаалтныг ажилд томилох, чөлөөлөх, компанийн орон тоо, цалингийн сангийн хэмжээг тогтоох, компанийн ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг батлах, тэдэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээг батлах зэрэг компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.



### **Арав. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл тайлан, ногдол ашгийн хуваарилалт**

- 10.1. Компанийн санхүүгийн жил жил бүрийн 1-р сарын 1-ээс эхэлж, 12-рсарын 31-нд дуусгавар болно.
- 10.2. Компани нь санхүүгийн тайлангаа “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль, “Аудитын тухай” хууль болон бусад хуулийн дагуу баталгаажуулан үүний үндсэн дээр татварын багц хуулийн заалтанд нийцүүлэн тогтоосон хугацаанд нь татвараа тодорхойлон төлж, татварын тайлан гаргаж тооцоо хийнэ. Санхүүгийн тайланг мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу санхүү, татварын байгууллага, Үнэт цаасны хороо, Хөрөнгийн биржид хуулийн хугацаанд хүргүүлнэ.
- 10.3. Санхүүгийн тайланд дараах бүрдэл хэсгүүдийг заавал оруулна.
- Баланс
  - Орлого үр дүнгийн тайлан
  - Мөнгөн гүйлгээний тайлан
  - Хуримтлагдсан ашгийн тайлан
  - Тайлангийн тайлбар, тодруулга, илтгэх хуудас



- 10.4. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг гүйцэтгэх захирал хариуцна. Компанийн орон тоонд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа ерөнхий нягтлан бодогч энэхүү хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.
- 10.5. Хяналт шалгалт, лавлагаа, түүх архивын зорилгоор дараах баримт бичгүүдийг хуульд заасан хугацаагаар хадгална.
  - компанийн дүрэм түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд
  - компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ
  - компанийн дотоод бичиг, баримт, материалууд
  - компанийн салбар болон төлөөлөгчийн газрын дүрэм, гэрээнүүд
  - нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн нотлох баримт бичгүүд
  - компанийн ерөнхий захирлын болон гүйцэтгэх захирлын тушаал шийдвэр, хурал зөвлөлгөөний тэмдэглэл
  - санхүү аж ахуйн үйл ажиллагааны анхан шатны болон дэлгэрэнгүй бүртгэл, ня-бо бүртгэлийн баримт, бичиг, материалууд
  - санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцэл түүнтэй холбогдох баримт материалууд
- 10.6. Компанийн нягтлан бодох бүртгэлийг хөтлөх нэгж нь төгрөг байх бөгөөд эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн орлого, зарлага, өр, авлагын гүйлгээг тухайн ажил гүйлгээ хийгдсэн валютаар болон төгрөгөөр бүртгэлд тусгана. Валютаар хийгдсэн ажил гүйлгээг төгрөгт шилжүүлэхдээ тухайн өдрийн Монгол банкны албан ханшийг баримтлана.
- 10.7. Компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг санхүүгийн тайлан холбогдох анхан шатны нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтэд үндэслэн эрх бүхий татварын болон хөндлөнгийн хяналтын байгууллага шалгах эрхтэй бөгөөд компанийн эрх бүхий албан тушаалтан холбогдох баримт, маягтыг шаардлагын дагуу толилуулах үүрэг хүлээнэ.
- 10.8. Компани Монгол Улсын аль нэг болон хэд хэдэн банкинд төгрөгийн болон валютын данс нээх бөгөөд шинээр данс нээлгэсэн, хаалгасан тухай бүр Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж байна. Компани гадаадын банкинд валютын данс нээх бол энэ тухайгаа Монгол банк болон татварын албанд албан ёсоор мэдэгдэнэ.
- 10.9. Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна.



А. Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх.



Б. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх.

В. Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

10.10. Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас илүү хувиар багассан тохиолдолд ногдол ашгаа шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдэл хэмжээг бичгээр мэдэгдэнэ.

10.11. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээ, үйлдвэр хөгжүүлэх сан байгуулж болно. Санг байгуулах асуудал ТУЗ шийдвэрлэнэ. Уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг гүйцэтгэх захирал боловсруулж ТУЗ-ийн хурлаар баталж мөрдөнө.



**Арван нэг. Компанийн санхүү, эдийн засгийн  
үйл ажиллагаанд тавих хяналт**

Аудиторын хяналт

11.1.1. “Аудитын тухай” Монгол Улсын хуульд заасны дагуу компанийн санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийх зорилгоор ТУЗ-ийн хурлаас сонгосон эрх бүхий аудитын байгууллагатай гэрээ байгуулан ажиллана.

11.1.2. Гэрээг ТУЗ-ийн хурлаар батлах бөгөөд гэрээнд аудиторын эрх үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заана.

11.1.3. Компанийн эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримтыг танилцуулах үүрэгтэй.

11.1.4. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны хийх аудиторын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна. Компанийн жилийн санхүүгийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит шалгалт хийнэ.


11.1.5. Ээлжит бус шалгалтыг ТУЗ-ийн хурлын шийдвэр, компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч болон гүйцэтгэх захирлын шийдвэрээр хэдийд ч хийж болно. Аль нэг хувь цаа эзэмшигчийн захиалгаар хийгдсэнээс бусад шалгалтын хөлсийг компани хариуцаж төлнө. Хувьцаа эзэмшигчийн захиалгаар хийгдсэн шалгалтын хөлсийг тухайн хувьцаа эзэмшигч хариуцаж төлөх бөгөөд шалгалтын явцад эрх бүхий албан тушаалтан эсхүл хувьцаа



эзэмшигч компани, хувьцаа эзэмшигч болон зээлдүүлэгчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

11.1.6. Дараах этгээдийг компанийн аудиторроор сонгон ажиллуулахыг хориглоно.

- А. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий тушаалтан.
- Б. Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, компани болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд холбогдох бусад эд хөрөнгө буюу хөрөнгийн эрх эзэмшдэг бол
- В. Компанитай аудитаас бусад асуудлаар гэрээ хэлбэл хийсэн бол



**Арван хоёр. Компанийг өөрчлөн байгуулах**


- 12.1. Компанийг өөрчлөн байгуулах тухай ойлголтод компанийн хуваах бусад компанитай нийлэх, нэгдэх, тусгаарлах, өөрчлөх асуудлууд хамаарагдана.
- 12.2. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг “Компаний тухай” хуулийн 18-21 дүгээр зүйлийн заалтуудыг үндэслэн шийдвэрлэнэ.

**Арван гурав. Компанийг татан буулгах**

- 13.1. Компанийг дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгана. Үүнд:
  - Компанийн үйл ажиллагаа алдагдалтай байгаагаас цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон.
  - Компанийг татан буулгахыг хувьцаа эзэмшигчдийн дийлэнхи олонхи зөвшөөрсөн.
  - “Компанийн тухай” хуулийн 30.3-д заасан үндэслэл
  - Хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхи нь компанийг хуваах, өөр компанид нэгдэх шийдвэр гарсан.
- 13.2. Монгол Улсын шүүх компанийг дор дурдсан үндэслэлээр татан буулгана
  - Дампуурсан
  - Нэг ч гишүүн үлдээгүй
  - Хуульд заасан бусад үйлдэл
- 13.3. Татан буулгах шийдвэр гаргасан гишүүдийн хурлаас татан буулгах комиссыг томилно. Хурлын дарга татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараагаар компанид үлдэж



- байгаа эд хөрөнгийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төсөл, хуваах юм уу нэгдэх шийдвэр гаргасан бол хуваах болон нэгдэх төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж шийдвэрлүүлнэ.
- 13.4. Татан буулгах комисс томилсноор тухайн компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжих бөгөөд уг комисс нь компанийн нэрийн өмнөөх шүүх хуралд оролцоно.
- 13.5. Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас компанид, эсвэл зээлдүүлэгчдэд ямар нэг хохирол учруулсан бол уг хохирлыг хуульд заасан журмын дагуу хариуцна.
- 13.6. Татан буулгах комисс нь компанийг татан буулгах болон нэхэмжлэл гаргах хугацаа, журмыг нийтэд болон зээлдүүлэгчдэд мэдээлнэ.
- 13.7. Нэхэмжлэл гаргах хугацаа дууссан өдрөөр тасалбар болгон компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх зээлдүүлэгчдийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын дүнг тусгасан татан буулгах түр балансыг гаргах бөгөөд уг балансыг гишүүдийн хурал батална.
- 13.8. Татан буулгах комисс нэхэмжлэлийг хэрхэн барагдуулах тухайгаа нэхэмжлэгчдэд бичгээр мэдэгдэнэ.
- 13.9. Компанийн мөнгөн хөрөнгө нь нэхэмжлэлийг барагдуулахад хүрэлцэхгүй бол гишүүдийн хурлын зөвшөөрлөөр компанийн эд хөрөнгийг худалдаж болно. Зээлдүүлэгчдийн өр төлбөрийг барагдуулсны дараа үндсэн эд хөрөнгө, эд хөрөнгө, эсвэл тэдгээрийг зээлдүүлэгчдийн өр төлбөрийг барагдуулсны дараа үндсэн эд хөрөнгө, эд хөрөнгө эсхүл тэдгээрийг худалдаж борлуулсан орлогыг хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны тоотой хувь тэнцүүлж хуваарилна.
- 13.10. Компанийн эд хөрөнгийг хуваарилсны дараа татан буулгах комисс компанийг татан буулгах замаар үйл ажиллагаа дуусгавар болсныг бүртгэх байгууллагад мэдэгдэж, татан буулгах балансын нэг хувийг хүргүүлнэ.
- 13.11. Компани нэгдэх, өөрчлөн зохион байгуулснаас үйл ажиллагаа нь дуусгавар болж байгаа тохиолдолд бүртгэх байгууллага болон олон нийт, зээлдүүлэгчдэд хүргэх мэдэгдэлд компанийн эрх үүргийг шилжүүлэх, авсан хуулийн этгээдийн нэрсийг заана.
- 13.12. Хуваагдсаны улмаас компанийн үйл ажиллагаа дуусгавар болсон бол хуваах балансын дагуу компанийн эрх үүргийг шилжүүлж авсан компани тус бүрийн нэрсийг мэдээлнэ.





28

13.13. Бүртгэх байгууллага компанийг улсын бүртгэлээс хассанаар татан буулгасанд тооцно.

**Арван дөрөв. Дүрэм хүчин төгөлдөр болох**

- 14.1. Энэ дүрмийг монгол хэлээр 3 хувь үйлдэж нотариатаар гэрчлүүлэн нэг хувийг нотариатад, нэг хувийг Улсын бүртгэлийн албанд, нэг хувийг компани оортоо хадгална.
- 14.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталж улсын бүртгэлд бүртгүүлснээр энэхүү дүрэм хүчин төгөлдөр болно.



ХЭХ-ЫН ДАРГА

П.БҮҮВЭЙБААТАР

ОЛЛОО ХК

УЛААНБААТАР ХОТ  
ТТА 22324/2861836





19

## “ОЛЛОО” ХК-ИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Компанийн оноосон нэр:
  - А. “Оллоо” ХК (монголоор)
  - Б. “OLLOO” (англиар) гэж нэрлэнэ.
- 1.2. Компанийн оршин байгаа хаяг:

Баянгол дvврэг, 11-р хороо, Ивээл группын байр, Бvрүүсv 27 давхарга

Харилцах утас: 976-772-01100

Факс: 976-772-01100
- 1.3. “Оллоо” ХК нь (цаашид компани гэнэ) Компанийн тухай Монгол Улсын хуулийн дагуу зохион байгуулагдсан, бие даасан тайлан тэнцэлтэй, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх хуулийн этгээд бөгөөд хувьцаа эзэмшигчидийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагдах нээлттэй хувьцаат компани болно.
- 1.4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааны бүртгэлийг энэхүү дүрмийн салшгүй хэсэг болгон хавсаргав.
- 1.5. Компани нь орлого ашгаа арвижуулах замаар хувьцаа эзэмшигчдийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх явдлыг үндсэн зорилгоо болгон үйл ажиллагаагаа дараах чиглэлээр явуулна.
  - 1.5.1. Бөөний худалдаа
  - 1.5.2. Гадаад худалдаа
  - 1.5.3. Компьютерийн худалдаа
  - 1.5.4. Онлайн сүлжээ
- 1.6. Компани нь байгууллагынхаа дотоод журмыг ажиллагсадаараа хэлэлцүүлэн баталж мөрдөнө.
- 1.7. Компани нь үйл ажиллагаагаа зохицуулах, ашиг сонирхолоо төрийн өмчийн болон бусад байгууллагад төлөөлөх зорилгоор өмчийн хэлбэр, эдийн засгийн хэвшлийг үл харгалзан өөрийн орны болон гадаадын корпораци, концерн, компани, бирж, хориоо зэрэг аж ахуйн нэгжтэй үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа, зуучлалын үйл





ажиллагааг хорших, хамтран ажиллах, хувь нийлүүлэх зэрэг зохион байгуулалтын дэвшилттэй хэлбэрийг сонгон ажиллаж болно.

- 1.8. Компани нь өөрийн эд хөрөнгө, байр талбайг үндсэн үйлдвэрлэлийн бус зориулалтаар ашиглах, бусад түрээсээр эзэмшүүлж болно.
- 1.9. Компани өөрийн албан бичгийн хуудас, тамга тэмдэгтэй байна.
- 1.10. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.
- 1.11. Компани нь өөрийн салбар эсвэл төлөөлөгчийн газрыг бусад аймаг, хот, сум, дүүрэг, хороонд ажиллуулж болно. Үүнийгээ хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлнэ.
- 1.12. Компанийн бүтээгдэхүүн нь Монгол улсын болон олон улсын тухайн бүтээгдэхүүний стандартыг хангасан байна.
- 1.13. Компани байгуулагдсанаас хойш хязгааргүй жил үйл ажиллагаагаа явуулна.
- 1.14. Компанийн дүрмийн сан нь 1 005 600,0 мянган төгрөг байна. Энэ хөрөнгө нь хувьцаа эзэмшигчидийн хөрөнгөөс бүрдэнэ.
- 1.15. Компанийн нэгж хувьцаа 100 төгрөгийн үнэтэй 9 700 497 /есөн сая долоон зуун мянга дөрвөн зуун ерөн долоон/ ширхэг хувьцаа гаргасан болно.
- 1.16. Үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлэх болон бусад үйлчилгээний тусгай зөвшөөрөл авахад компанийн дүрмийн санг нэмэгдүүлж болох бөгөөд оруулсан хөрөнгийн хэмжээгээр хувь эзэмшинэ.

#### Хоёр. Компанийн үндсэн эрх

- 2.1. Компани нь өөрийн бараа үйлчилгээний тэмдэг, бэлэгдэлтэй байж болох бөгөөд түүний загварыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөл батална. Бэлэгдэл, барааны тэмдэгийг оюуны өмчийн газарт бүртгүүлэх бөгөөд тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн "Оллоо" компани эдэлнэ.
- 2.2. Компани нь өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар эсвэл бусадтай хамтран Монгол Улсын хуулийн хүрээнд эрхлэн явуулна.
- 2.3. Компани өөрийн үйл ажиллагаагаа өргөтгөх, үйлчлүүлэгчид болон зах зээлдээ ойртох зорилгоор улс дотроо болон гадаадад салбар төлөөлөгчийн газар ажиллуулж болно.
- 2.4. Компаний үндсэн ба туслах үйлдвэрлэл, үйлчилгээний ажлыг хэвийн явуулах зорилгоор мэргэжил чадвар сайтай, дадлага туршлагатай хүмүүсийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулах, тэдний ажиллах нөхцөл, цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.



- 20
- 2.5. Компани өөрийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой зарим зүйлийг хуулийн дагуу нууцална.
  - 2.6. Компанийн үйл ажиллагаа хэвийн явуулахтай холбогдсон мэдээлэл цуглуулах, мөн тэдгээр мэдээллийг үйлчлүүлэгч сонирхогчдод хүргэж болно.

#### **Гурав. Компанийн үндсэн үүрэг**

- 3.1. Компани нь энэхүү дүрмийн 1-ийн 5-д заасан үйл ажиллагааг Монгол Улсын хуульд заасны дагуу эрхлэх үүрэгтэй.
- 3.2. Компани нь Монгол Улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль, “Аудитын тухай” хуулийн дагуу нягтлан бодохын болон анхан шатны дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөн санхүүгийн тайлан тэнцэл гарган баталгаажуулж ажиллана.
- 3.3. Компани нь Монгол Улсын албан татварын хуулиудын заалтыг хатуу мөрдөн татвараа өөрөө тодорхойлж сайн дураар төлж байна.
- 3.4. Компани Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай мэдээ, мэдээллийг цаг тухай бүр эрх бүхий байгууллагуудад гаргаж өгч байна.
- 3.5. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын өмнө хуулиар өгөгдсөн үүргүүдийг биелүүлж ажиллана.
- 3.6. Компани нь улс эх орны нийгэм эдийн засгийн хөгжилд бололцооны хэрээр дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахын зэрэгцээгээр Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу байгаль орчныг хамгаалж ажиллана.



#### **Дөрөв. Компанийн үндсэн хариуцлага**

- 4.1. Компани нь өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээнэ.
- 4.2. Компани нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсадын эрхийг зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ.
- 4.3. Компани нь Монгол Улсын хуульд заасан бусад хариуцлагыг хүлээнэ.
- 4.4. Компанийн гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нар нь гэрээнд заагдсан хугацаанд эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд тэдгээр нь өөрийн хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлыг хариуцна.
- 4.5. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд “Компанийн тухай” хуулийн 81, 82 дугаар зүйлд заасан хариуцлагыг хүлээнэ.



Тав.Хувьцаа эзэмшигчдийн эрх

- 5.1. Компанийн энгийн хувьцааг худалдан авч эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.
- 5.2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах үед Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон “бүртгэх өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх эрхтэй.
- 5.3. Төлөөлөн удирдах зөвлөлөөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед эзэмшиж буй хувьцаанд оногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хуульд, ТУЗ-ийн шийдвэрт заасан хугацаанд олгоогүй бол алданги өлөхийг шаардах эрхтэй.
- 5.4. Компанийг татан буулгах үед “Компанийн тухай” хуулийн 28 дугаар зүйлд тогтоосон журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх эрхтэй.
- 5.5. Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй.
  - 5.5.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас доорхи асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг компани эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
    - А. Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгож өөрчлөх;
    - Б. Хэлцэл хийхийн өмнө сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргасан зэргээр их хэмжээний хэлцэл хийсэн;
    - В. Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг Компанийн дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай Компанийн дүрмийг шинэчилсэн найруулгыг баталсан;
- 5.6. Нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмшиж байгаа тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.





- 21
- 5.7. Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь ээлжит хурал хуралдахаас ажлын 45 хоног ба түүнээс дээш хоногийн өмнө хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ, эсхүл гүйцэтгэх удирдлагын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.
  - 5.8. Дээрх эрхээ эдлэх боломжоор хувьцаа эзэмшигчдийг хангахын тулд компанийн ТУЗ нь хурал хуралдахаас 2 сарын өмнө 5 ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч этгээдэд бичгээр мэдэгдэл хүргүүлнэ.
  - 5.9. Хувьцаа эзэмшигч нь “Компанийн тухай” хуулийн 66.4-т заасан мэдээлэлтэй танилцах эрхтэй.
  - 5.10. Энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх эрхтэй.



### Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн үүрэг

- 6.1. Компанийн гэрээ, дүрмийн заалтыг хэлбэрэлтгүй сахих;
- 6.2. Компанийн үйл ажиллагаанд бололцоотой бүх талын дэмжлэг үзүүлэх;
- 6.3. Компанийн хувьцааг давуу эрхээр худалдан авах тухай саналаа хувьцааг худалдах шийдвэр гарснаас хойш ажлын 30 хоногийн дотор ирүүлэх;
- 6.4. Компанийн нууцыг чандлан хадгалах;
- 6.5. Хувьцаа эзэмшигчдийн хоорондын харилцаанд чин шударга хандах;
- 6.6. Компанид хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа бол эрхэлсэн ажлаа үлгэр жишээ биелүүлэх;
- 6.7. Хувьцаа эзэмшигч өөрийн буруугаас компанид учруулсан хохирлыг бүрэн хариуцаж төлнө. Хохирол төлүүлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш ажлын 12 хоногийн дотор төлбөрийг компанид төлнө.
- 6.8. Хувьцаа эзэмшигч төлбөр төлөхөөс татгалзсан буюу зайлсхийсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр түүний ногдох хувь буюу тухайн жилд олгогдвол зохих ногдол ашгийн хэмжээг төлбөрийн дүнгийн хэмжээгээр хасч болно. Ийм боломжгүй тохиолдолд төлбөрийг шүүхийн журмаар шийдвэрлэнэ.

### Долоо. Хувьцаа эзэмшигчдэд хориглох зүйл, хүлээх хариуцлага

- 7.1. Компанийн нэрийг хувийн ашиг сонирхолд ашиглахыг хориглоно.
- 7.2. Компанийн нэр хүнд, өмч хөрөнгөд гэм хор учруулж болзошгүй ямарваа үйлдэл хийхийг хориглоно.

- 7.3. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 7.4. Компанийн ТУЗ-ийн гишүүн, эсхүл эрх бүхий албан тушаалтан болсон хувьцаа эзэмшигч нь өөрийн буруутай үйл ажиллагаанаас компанид учруулсан эд хөрөнгийн хохирлыг өөрийн хөрөнгөөр компанийн өмнө хариуцна.

**Найм. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө,  
Хувьцаа, бусад үнэт цаас, түүнийг гаргах,  
Худалдах болон эргүүлэн авах**



- 8.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө хувьцаанд хуваагдаж байгаа бөгөөд компанийн зарласан хувьцаа нэг бүр нь 100 төгрөгийн үнэтэй 9 700 497 ширхэг энгийн хувьцаа байна.
- 8.2. Дүрмийн 8.1.-д заасан зарласан хувьцаанаас үйлдвэрлэл үйлчилгээг өргөтгөх, шинэчлэх нэмэгдэл хөрөнгийн эх үүсвэр бий болгох зорилгоор нэмж хувьцаа гаргах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ.
- 8.3. Нэмж гаргасан хувьцааг компанийн хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжинд худалдаж авах давуу эрхтэй. Мөн Монгол улсын ба гадаадын иргэд худалдан авч болно.
- 8.4. Энэ давуу эрхийг “Компанийн тухай” хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу хэрэгжүүлэх үүргийг ТУЗ хүлээнэ.
- 8.5. Компани давуу эрхийн хувьцаа гаргаж болно. Давуу эрхийн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх зэргийг тухай бүр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 8.6. Гаргасан хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болох бөгөөд энэ тохиолдолд хувьцааны төлбөрт хүлээн авч байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, оюуны өмчийн үнэлгээг эрх бүхий үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн ТУЗ тогтооно.
- 8.7. Компани үйл ажиллагааны зарим чиглэлээр охин компани байгуулан дүрмийн сангаа тэр хэмжээгээр хорогдуулж болно.
- 8.8. Компанид шинээр хувь нийлүүлэн оруулсан хөрөнгийн бүртгэлийн жагсаалтыг улсын бүртгэлийн материалд тухай бүр оруулж байна.
- 8.9. Энэхүү хөрөнгөнд тухайлбал үл хөдлөх хөрөнгийн хувьд үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ, үл хөдлөх хөрөнгөнд хөндлөнгийн байгууллага буюу хөрөнгийн үнэлгээний компанийн тайланг хавсаргаж баталгаажуулна.